



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/96

Булган сум

Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах
богино хугацааны сургалт зохион байгуулахад
хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сургалт зохион байгуулахад шаардагдах 10,074,800 (арван сая далан дөрвөн мянга найман зуу) төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



02 Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

**Багийн Засаг дарга нарт зохион байгуулах
сургалтын төсвийн тооцоо**

Д/д	Нэр	Нэгж үнэ	Тоо, ширхэг	Тооцоо	Давтамж	Нийт
1	2	3	4	5	6	7
1	Багш нарын хоол	35,000	4	Өглөө 4*25000 Өдөр 4*35000 Орой 4*35000	4 удаа	1,220,000 420,000
2	Буудал	160,000	2 өрөө	2*160000	2	640,000
3	Багийн Засаг дарга нарын хоол	Зутан- 9000 Хоёрдугаар хоол -15000	76	Зутан шөл - 1.9000*76/684000 2.15000*76/1,14000 3.15000*10/300,000	2	3,648,000 300,000
4	Өдрийн завсарлага	7500	90	Өдрийн завсарлага -15000*90/1140000 320,000	4	3,020,000
5	Бичиг баримт, хэрэглэгдэхүүний зардал	3800	76	-	-	300,000
6	Бензин	2520	30	-	-	120,000
7	Багш нарын орон нутагт зорчих тээврийн зардал	406,800	4	-	-	406,800
Нийт- 10,074,800						